

МУИС-д профессор, багш ажиллуулах журам

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. МУИС-д профессор, багш ажиллуулах, багшийн эрх, үүрэг, багшид тавигдах шаардлага, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, чадахуйн (мерит) зарчимд тулгуурласан мэдлэг ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалын зэрэглэлийг тогтоох үйл ажиллагаатай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Инновацын тухай хууль мөн МУИС-ийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн энэхүү журмыг баримтална.

Хоёр. Журмын нэр томьёо

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. “МУИС-ийн багш” гэж МУИС-д орон тоонд ажиллаж буй магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, сургалт судалгааны ажлыг хослуулан хийдэг, судалгааны болон заах арга зүй эзэмшсэн иргэнийг;
 - 2.1.2. “судалгаа” гэж шинэ мэдлэг, онол арга зүй, хэрэглээ инновацыг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотойгоор бий болгох, хөгжүүлэх, турших, хэрэгжүүлэн нэвтрүүлэхэд чиглэсэн суурь ба хэрэглээний шинжтэй эрдмийн үйл ажиллагааг;
 - 2.1.3. “суурь судалгаа” гэж байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологийн шинэ мэдлэг, онол, арга зүйг бий болгоход чиглэсэн эрдмийн үйл ажиллагааг;
 - 2.1.4. “судалгааны төсөл” гэж нэг талаас аль нэг хуулийн этгээд захиалж, нөгөө талаас судалгааны баг гүйцэтгэлийг хариуцсан, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох зорилготой, захиалагчаас санхүүжүүлсэн бие даасан төсөвтэй, тодорхой хугацаатай гүйцэтгэхээр төлөвлөсөн судалгааны ажлыг;
 - 2.1.5. “судалгааны үр дүн” гэж судалгааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ мэдлэг, онол арга зүй болон хэрэглээ, байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологийн шийдлийг;
 - 2.1.6. “гадаадтай хамтарсан төсөл” гэж гадаадын байгууллага, судлаачидтай хамтран хэрэгжүүлэх судалгааны төслийг;
 - 2.1.7. “гадаад төсөлд оролцох” гэж гадаадын байгууллагын санхүүжилттэй төсөлд удирдагч, гүйцэтгэгчээр оролцохыг;
 - 2.1.8. “үндсэн багш” гэж МУИС-д хөдөлмөрийн гэрээний дагуу бүрэн ачаалалтай орон тоонд ажиллаж буй багшийг;
 - 2.1.9. “зорилтот орон тоо” гэж профессорын зэрэглэлд бүрэн ачаалалтай ажиллах багшийн үндсэн орон тоог;
 - 2.1.10. “зорилтот бус орон тоо” гэж судалгааны профессор, дэд профессор, зөвлөх, зочин профессор, гэрээт, цагийн багшийн үндсэн бус орон тоог;
 - 2.1.11. “судалгааны гэрээт профессор, дэд профессор” гэж судалгаа голлож хийдэг бөгөөд МУИС-ийн бус эх үүсвэрээс санхүүжин цалинжих зорилтот бус орон тоонд ажиллаж буй судлаачийг;
 - 2.1.12. “сурах бичиг” гэж суралцагчдад тухайн шинжлэх ухаан, түүний аль нэг салбарын үндсэн мэдлэг, ойлголт, категори, зарчим, үзэл баримтлалуудын талаар системтэй мэдлэг олгох, боловсролын стандарт, хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцахуй, багшлахуйн нэгдлийг хангахад шаардлагатай онол, арга зүйн үндэс бүхий дидактик шийдлийг цогцоор хэлбэржүүлсэн, тодорхой хичээлийн агуулгыг бүрэн багтаасан их сургуулийн сургалтад зориулсан хэвлэмэл эсвэл цахим бүтээлийг;
 - 2.1.13. “сургалтын гарын авлага” гэж тодорхой хичээлийн агуулгыг хэсэгчилсэн болон бүрэн байдлаар судлахад ашиглах боломжтой ном хэлбэрээр хэвлүүлсэн лекцийн тойм, дадлага, лабораторийн ажлын удирдамж, сорил, бодлого, дасгалын эмхэтгэл зэрэг практикт хэрэглэх чадвар эзэмшүүлэх зорилготой, сургалтад зориулсан сурах бичгээс бусад хэвлэмэл эсвэл цахим бүтээлийг;
 - 2.1.14. “монограф буюу нэг зохиогчтой нэг сэдэвт бүтээл” гэж шинжлэх ухааны тодорхой нэг сэдвээр нэг зохиогч бичиж гадаад болон дотоодод хэвлүүлсэн цогц бүтээлийг;

- 2.1.15. “нэг сэдэвт хамтын бүтээл” гэж редакторын удирдлага дор судалгааны нэг сэдвийн хүрээнд хамтарч бичиж гадаад болон дотоодод хэвлүүлсэн цогц бүтээлийг;
- 2.1.16. “эх бичгийн цогц судалгаа” гэж сурвалж бичгийг цогцоор нь судалж өгүүлэлд тавигдах шаардлагыг хангасан удиртгал, эрдэм шинжилгээний тайлбар, галиг, хөрвүүлэг, нэрийн заагуур, ном зүйтэй хэвлүүлсэн бүтээлийг;
- 2.1.17. “сурвалжийн эрдэм шинжилгээний орчуулга” гэж сурвалж бичгийг нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулж, удиртгал бичиж, эрдэм шинжилгээний тайлбар хийж хэвлүүлсэн бүтээлийг;
- 2.1.18. “архивын баримтын эмхэтгэл” гэж анхдагч эх сурвалжаас бичвэрт хөрвүүлж, өгүүлэлд тавигдах шаардлагыг хангасан удиртгал, баримтын жагсаалт, нэрсийн заагуур хийсэн бүтээлийг;
- 2.1.19. “хэлний толь бичиг” гэж хэлний нэгжийг тодорхойлолтын нь хамт буюу бусад хэлний дүйх орчуулгатай нь жагсаан байрлуулсан лавлагааны ном;
- 2.1.20. “нэвтэрхий толь бичиг” гэж практик үйл ажиллагаа болон мэдлэгийн нэг эсвэл бүхий л салбарын талаарх үндсэн мэдээг товч өгүүллийн маягаар тодорхойлж цагаан толгойн үсгийн дэс дарааллаар системчлэн байрлуулсан лавлагааны ном;
- 2.1.21. “нэр томьёоны толь бичиг” гэж мэдлэгийн нэгэн салбар буюу сэдвийн нэр томьёоны ойлголтыг тайлбартай нь багтаасан лавлагааны ном;
- 2.1.22. “нэмэлт хичээл” гэж багшийн нэг хичээлийн жилийн “А” цагийн ногдлоос илүү заасан хичээлийн нийт багц цаг;
- 2.1.23. “зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллуулах” гэж багш нь ажлын үнэлгээний шаардлага ханган тухайн зэрэглэлдээ үргэлжлүүлэн ажиллахыг;
- 2.1.24. “зэрэглэл ахих” гэж багш нь дараагийн зэрэглэлд дэвшин ажиллахыг
- 2.1.25. “зэрэглэл баталгаажих” гэж дэд профессор, профессор нь холбогдох шаардлагыг бүрэн хангасан, тухайн зэрэглэлд шалгаруулалтгүйгээр ажиллах эрхийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр батламжилсныг ойлгоно.

Гурав. Багшийн эрх

- 3.1 Багш нь Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, мөн МУИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журамд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ:
 - 3.1.1 судалгааны сэдэв, арга зүйг бие даан шийдэх, судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хараат бусаар хэвлэн нийтлэх;
 - 3.1.2 эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацын бүтээгдэхүүн, оюуны өмчөө хамгаалуулах;
 - 3.1.3 судалгааны ажлын нийтлэг чиглэл, хамтарсан эрдэм шинжилгээний ажил хэрэгжүүлэх тохиолдолд, багш үндсэн харьяаллын тэнхимээс гадна өөр бүрэлдэхүүн/салбар сургууль, бусад нэгжид давхар харьяалалтай ажиллах;
 - 3.1.4 профессор, дэд профессорын албан тушаалд ажиллаж буй багш сургалт, судалгааны лабораторийг байгуулах, удирдахаас гадна инновац, технологи дамжуулах үйл ажиллагаатай холбоотой нэгжийг санаачлан ажиллах;
 - 3.1.5 судалгааны үр дүнгээ эдийн засгийн эргэлтэд оруулж, шимтгэл орлогоос хувь хүртэх, гарааны компани үүсгэн байгуулах;
 - 3.1.6 МУИС-ийн нэрээр эсвэл МУИС-тай хамтарсан судалгааны ажил гүйцэтгэхдээ МУИС-ийн материаллаг орчныг ашиглах;
 - 3.1.7 бүтээлийн чөлөө авах, бичиж туурвисан бүтээлээ хэвлэн нийтлүүлэхэд дэмжлэг авах;
 - 3.1.8 МУИС-ийн үйл ажиллагааны талаар сургуулийн захиргаанд санал дүгнэлтээ илэрхийлэх;
 - 3.1.9 түр сургалтад суралцах болон бусад хэлбэрээр мэргэшлээ дээшлүүлэхэд дэмжлэг авах;
 - 3.1.10 МУИС-ийн дүрэм, журам, хөгжлийн стратегийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад оролцох;
 - 3.1.11 МУИС-ийн нэр, лого, барааны тэмдгийг албан хэрэгцээнд холбогдох журамд заасны дагуу ашиглах;
 - 3.1.12 судалгааны суурь зардал авах;

- 3.1.13 багш, өөрийн удирдаж байгаа судалгааны дотоод болон гадаадын төсөл хөтөлбөрийн төсвийг холбогдох гэрээний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн захиран зарцуулах;
 - 3.1.14 профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багш нар болон МУИС-д профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаад МУИС-д удирдах албан тушаалд томилогдсон багш нар ахисан түвшний суралцагчдыг судалгааны болон сургалтын туслахаар ажиллуулах;
 - 3.1.15 зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
 - 3.1.16 багш нь өөрийн сургалт, судалгааны мэдлэг, чадамжид нийцэж буй МУИС-ийн хичээлийг заах санал өгөх, оюутан сонголтод үндэслэн хичээл заах;
- 3.2 МУИС-д зочин профессороор ажиллаж буй гадаадын харьяат иргэн тус сургуулийн төлөөллийн байгууллагыг сонгох, сонгогдохоос бусад эрхийг үндсэн багшийн нэгэн адил эдлэнэ.

Дөрөв. Багшийн үүрэг

- 4.1 Багш нь Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журамд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:
- 4.1.1 тухайн хичээлийн жилд энэ журмын 8.1-т заасан сургалт “А”, эрдэм шинжилгээ “Б”, нийгэм, олон нийтэд хандсан үйлчилгээний “В” цагийн ногдол тус бүрийг биелүүлэх;
 - 4.1.2 өөрийн зааж буй хичээлийн хөтөлбөр, суралцагчдын дүн, хичээл, сургалтын хэрэглэгдэхүүний талаар сургалт хариуцсан нэгжид шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, сургалтын цахим мэдээллийн санд оруулах;
 - 4.1.3 тогтоосон хугацаанд эрдэм шинжилгээ, сургалтын болон бусад ажлаа тайлагнаж үнэлүүлэх, багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд хамрагдах;
 - 4.1.4 мэдлэг, боловсролоо дээшлүүлэх талаар санаачилгатай ажиллах, мэргэжлийн салбарт гарсан нээлт, ололтыг өөрийн зааж буй хичээлийн агуулгад тусгадаг байх;
 - 4.1.5 байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр чанарын баталгаажуулалт, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад оролцох;
 - 4.1.6 багшийн болон шинжлэх ухааны судалгааны ёс зүйн дүрэм, журмыг мөрдөж ажиллах;
 - 4.1.7 багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөө боловсруулан тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн төлөвлөгөөнд тусгаж тасралтгүй хөгжих;
 - 4.1.8 МУИС-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу мэргэжлээрээ нийгэмд үйлчлэх, соён гэгээрүүлэх, сурталчлах ажилд оролцох;
 - 4.1.9 өвчтэй, чөлөөтэй болон томилолтоор явсан багшийн хичээлийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчтэй тохиролцож орлон заах;
 - 4.1.10 бусад багш нарын мэдлэг, боловсролыг дээшлүүлэхийг дэмжих, ажлыг үнэлэхэд оролцох;
 - 4.1.11 суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлгээний ил тод, нээлттэй аргаар шударга дүгнэх;
 - 4.1.12 үндсэн үүрэгт ажлаа зохих ёсоор гүйцэтгэхэд ажлын цагийг бүрэн зарцуулж бусад их, дээд сургуульд үндсэн орон тоонд багшаар ажиллахгүй байх.

Тав. Багшийн орон тоог тогтоох

- 5.1 МУИС нь өөрийн эрдэм шинжилгээ, сургалтын бодлогод нийцүүлэн, профессорын зэрэглэлд ажиллах багшийн зорилтот орон тоог 3 жил тутам МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна. Батлуулсан зорилтот орон тоог энэ хугацаанд өөрчлөхгүй.
- 5.2 МУИС-ийн багшийн орон тоог тогтоохдоо, нэг хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт багц цагийн 80-аас доошгүй хувийг үндсэн багш нар гүйцэтгэхээр тооцож тогтооно.
- 5.3 Үлдсэн 20 хүртэлх хувь нь зорилтот бус орон тоон дээр зөвлөх, зочин профессор, гэрээт, цагийн багшийн хэлбэрээр гүйцэтгэнэ.
- 5.4 Судалгааны гэрээт профессор, дэд профессор нь зорилтот бус орон тоонд ажиллана.

- 5.5 МУИС-ийн багшийн орон тоог сургалтын хөтөлбөр дэх багц цагийн хэмжээтэй уялдуулан хичээлийн жил бүр шинэчлэн тогтоож, МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж тушаалаар баталгаажуулна.
- 5.6 Бүрэлдэхүүн сургууль, хаврын улирал дахь суралцагчдын хувийн төлөвлөгөөнд үндэслэн, дараагийн хичээлийн жилийн намрын улирлын зорилтот бус орон тоог тогтоож элсэлт, бүртгэл хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 5.7 Судалгааны ажлын цар хүрээ, ажлын шаардлагаас хамааран бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөл дэмжсэн тохиолдолд судалгааны гэрээт дэд профессор, профессорын зорилтот бус орон тоог 2 жилээс богино хугацаагаар гэрээ байгуулан ажиллуулахыг МУИС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.8 МУИС-д дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллаж байсан багш нь МУИС-ийн удирдах албан тушаалд ажиллахаар томилогдсон бол зорилтот орон тоог нь хадгалах бөгөөд тухайн албан тушаалын зэрэглэлд шаардлага хангасан багшийг түр хугацаагаар ажиллуулж болно.
- 5.9 Давхар харьяалалтай багшийн профессорын зорилтот орон тоо үндсэн тэнхимд нь харьяалагдана.
- 5.10 Багш бусад тэнхимд давхар харьяалалтай болохын тулд давхар харьяалуулах бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. Шийдвэрийг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

Зургаа. Багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлага

- 6.1 МУИС-ийн багшийн албан тушаалыг тухайн салбар, хөтөлбөр, мэргэжлийн чиглэлээр хийж буй судалгаа, сургалтын ажлын чанар, үр дүнг харгалзан дараах албан тушаалын зэрэглэлд Хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулна:
 - 6.1.1 профессор;
 - 6.1.2 дэд профессор;
 - 6.1.3 ахлах багш;
 - 6.1.4 багш
- 6.2 Багшийн зэрэглэлд шинээр ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 6.2.1 магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх;
 - 6.2.2 их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багш, эрдэм шинжилгээний ажилтнаар 3-аас доошгүй жил (Хөдөлмөрийн болон Хөлсөөр ажиллах гэрээний хугацааг тооцно.) ажилласан байх, докторын зэрэгтэй бол ажилласан жил шаардахгүй;
 - 6.2.3 тухайн мэргэжлийн онолын өндөр мэдлэгтэй байх;
 - 6.2.4 хичээлийн агуулга, арга зүйг боловсруулах чадвартай, заах арга зүй эзэмшсэн байх;
 - 6.2.5 докторын зэрэгтэй бол олон улсын мэргэжлийн хянан магадлагаа бүхий сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор 1-ээс доошгүй өгүүлэл, магистрын зэрэгтэй бол олон улсын мэргэжлийн хянан магадлагаа бүхий сэтгүүлд 1 өгүүлэл эсвэл МУИС-д бүртгэлтэй дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 2-оос цөөнгүй өгүүлэл нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх;
- 6.3 Ахлах багшийн зэрэглэлд эхэлж ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 6.3.1 докторын зэрэгтэй байх;
 - 6.3.2 их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багш, эрдэм шинжилгээний ажилтнаар 6-аас доошгүй жил (Хөдөлмөрийн болон Хөлсөөр ажиллах гэрээний хугацааг тооцно.) ажилласан байх;
 - 6.3.3 сургалтын агуулга, арга зүйг эзэмшсэн, сургалтад шинэ арга технологи нэвтрүүлэн ажилладаг байх;
 - 6.3.4 судалгааны төсөлд гүйцэтгэгчээр оролцдог байх;
 - 6.3.5 суралцагчийг үнэлэх үнэлгээний арга зүй эзэмшсэн байх;
 - 6.3.6 олон улсын мэргэжлийн хянан магадлагаа бүхий сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл, үүнээс нэгдүгээр, холбоо баригч зохиогчоор 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн эсвэл МУИС-д бүртгэлтэй дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх;
 - 6.3.7 Хавсралт 1-ийн Хүснэгт 1 дэх ахлах багшийн зэрэглэл ахих оноог биелүүлсэн байх;
- 6.4 Дэд профессорын зэрэглэлд эхэлж ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 6.4.1 докторын зэрэгтэй байх;

- 6.4.2 их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багш, эрдэм шинжилгээний ажилтнаар 9-өөс доошгүй жил (Хөдөлмөрийн болон Хөлсөөр ажиллах гэрээний хугацааг тооцно.) ажилласан байх;
- 6.4.3 дэд профессорын зэрэглэлийн эрдэм шинжилгээний бүтээлийг дараах 3 шаардлагын аль нэгийг биелүүлсэн нөхцөлд тооцно:
 - 6.4.3.1 Web of Science болон Scopus-ийн индекс бүхий мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн байх;
 - 6.4.3.2 олон улсын мэргэжлийн хянан магадлагаа бүхий сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн байх;
 - 6.4.3.3 нэг зохиогчтой нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн байх.
- 6.4.4 судалгааны төслийн удирдагч эсвэл голлох судлаачаар (төсөлд голлох судлаачийг тодорхойлсон байх эсвэл цалингийн хэмжээ болон эрдэм шинжилгээний бүтээлийн оролцоогоор нотлох) ажилладаг байх;
- 6.4.5 их, дээд сургуулийн түвшний сурах бичиг зохиосон эсвэл зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй орчуулж хэвлүүлсэн байх;
- 6.4.6 Хавсралт 1-ийн Хүснэгт-1-ийн дэд профессорын зэрэглэл ахих оноог биелүүлсэн байх;
- 6.5 Профессорын зэрэглэлд эхэлж ажиллахад дараах шаардлагыг хангана:
 - 6.5.1 их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багш, эрдэм шинжилгээний ажилтнаар 12-оос доошгүй жил (Хөдөлмөрийн болон Хөлсөөр ажиллах гэрээний хугацааг тооцно.) ажилласан байх;
 - 6.5.2 сургалт, судалгааны тодорхой салбар, чиглэл, сэдвийг хариуцах, бусад багш, судлаачдыг удирдан чиглүүлэх, манлайлах, судалгааны төсөл, сургалтын хөтөлбөр боловсруулах чадвартай байх;
 - 6.5.3 Web of Science IF JCR¹, Scopus индекстэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх, (үүний 3-аас доошгүй нь нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор), эсвэл гадаадад нэг зохиогчтой нэг сэдэвт бүтээл бичиж хэвлүүлсэн байх;
 - 6.5.4 МУИС-ийн санхүүжилтээс бусад эх үүсвэр бүхий 2-оос доошгүй эрдэм шинжилгээний төсөл удирдан хэрэгжүүлсэн байх;
 - 6.5.5 их, дээд сургуулийн түвшний сурах бичиг зохиосон байх (байгалийн ухаан болон инженерийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, орчуулгын эрхтэй хэвлэгдсэн сурах бичгийг тооцно.);
 - 6.5.6 бакалаврын түвшний ерөнхий суурийн эсвэл бакалаврын түвшний мэргэжлийн суурийн хичээл заадаг байх;
 - 6.5.7 докторантын эрдэм шинжилгээний ажил удирддаг байх;
 - 6.5.8 Хавсралт 1-ийн Хүснэгт-1-ийн профессорын зэрэглэл рүү ахих оноог биелүүлсэн байх.

Долоо. МУИС-д шинээр багш авах

- 7.1 МУИС нь тус сургуулийн стратеги төлөвлөгөөний дагуу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, эрдмийн зэрэгтэй, дотоод, гадаадын шилдэг эрдэмтдийг ажиллуулах бодлого баримтална:
 - 7.1.1 Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж /цаашид ЗХНХН гэх/ нь 2 жил тутам МУИС-д багшлах хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж МУИС-ийн захирлаар батлуулна.
 - 7.1.2 МУИС-д шинээр багш авахад багшлах хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөг баримталж энэхүү журмын 7.1.1 заалтыг үндэслэнэ.
- 7.2 Багшийн сонгон шалгаруулалтыг жил бүрийн 1-р сарын 15, 9-р сарын 15-наас эхлэн 5 сарын хугацаанд багтаан зохион байгуулна.
- 7.3 МУИС-д багшийг дараах хоёр хэлбэрээр авч ажиллуулна:
 - 7.3.1 Боловсрол шинжлэх ухааны яамны тушаалаар батлагдсан дээд боловсролын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага болон тухайн албан тушаалын зэрэглэлийн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулалтаар;
 - 7.3.2 Өндөр мэргэшлийн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр урих.

¹ Web of Science IF JCR¹-ийн өгүүлийг байгаль, инженерийн салбарт заавал шаардана.

- 7.4 Багшийн сонгон шалгаруулалтыг үндсэн орон тоон дээр, нээлттэй зарлана.
- 7.5 Тухайн багшийн зэрэглэлийн шаардлагыг бүрэн хангасан иргэнийг, тэнхимийн цагийн ачаалал, судалгааны ажлын цар хүрээ, ажлын шаардлагаас хамааран 2 жил хүртэлх хугацаагаар гэрээ байгуулан ажиллуулж болно.
- 7.6 Багшийн сонгон шалгаруулалт, өндөр мэргэшлийн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүй багшаар авах зохион байгуулалтыг ЗХНХН хариуцна.

А. Багшийг сонгон шалгаруулалтаар авах

- 7.7 Багшийн сонгон шалгаруулалт нь дараах үе шаттай байна:
 - 7.7.1 Мэргэжлийн тэнхим нь багш авч ажиллуулах орон тооны зэрэглэл, багшид тавигдах судалгааны болон мэргэжлийн тусгай шаардлага, ур чадварыг тэнхимийн хамт олноор хэлэлцүүлэн харьяа бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд санал хүргүүлнэ.
 - 7.7.2 Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа нь сонгон шалгаруулалтаар авах багшийн шаардлагад үндэслэн Элсэлт бүртгэл болон хөтөлбөр хариуцсан нэгжээс /цаашид ЭБХХН гэх/ дараах мэдээллийг авч дүгнэлт гаргана:
 - 7.7.2.1 МУИС-ийн багшлах хүний нөөцийн төлөвлөгөө;
 - 7.7.2.2 өмнөх 2 хичээлийн жилийн дөрвөн улиралд тухайн багшийн заах мэргэжлийн хичээлийн хэрэгжилт;
 - 7.7.2.3 тухайн тэнхимийн багш нарын цагийн гүйцэтгэл;
 - 7.7.2.4 бусад бүрэлдэхүүн сургуулийн ижил мэргэжлийн багш нарын цагийн ачаалал.
 - 7.7.3 Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа нь тэнхимийн санал, хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлэлцэн багшийн сонгон шалгаруулалт зарлах эсэх талаар шийдвэр гаргана.
 - 7.7.4 Шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт ЗХНХН-д хүргүүлнэ.
 - 7.7.5 ЗХНХН сонгон шалгаруулалтын зарыг 3-аас доошгүй долоо хоногийн турш үндэсний өдөр тутмын хэвлэл болон сургуулийн цахим хуудсаар монгол, англи хэлээр давтамжтай мэдээлнэ.
 - 7.7.6 Зарыг анх нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор багшид тавигдах шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй иргэн дараах баримт бичгийг бүрдүүлж ЗХНХН-д хүргүүлнэ:
 - 7.7.6.1 нэр дэвших тухай хүсэлт;
 - 7.7.6.2 эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт түүний нотлох баримт;
 - 7.7.6.3 төрийн албан хаагчийн анкет;
 - 7.7.6.4 иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 7.7.6.5 ажилласан жилийг нотлох баримт бичиг;
 - 7.7.6.6 бакалавр ба түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
 - 7.7.6.7 судалгаа, сургалтын үйл ажиллагаа болон хувь хүний зан төлөв, мэргэжлийн ёс зүйн талаар өөрийг нь сайн мэдэх, хамт ажиллаж байсан эрдэмтдийн битүүмжилсэн 3 тодорхойлолт;
- 7.8 ЗХНХН тогтоосон хугацаанд бүртгэлийн дугаар, овог нэр, төгссөн сургууль, холбоо барих утас, цахим хаяг, бүртгэсэн огноо, цагийг тэмдэглэж сонгон шалгаруулалтын бүртгэлийг эрхлэн явуулна. Тогтоосон хугацааг хэтрүүлсэн, мөн дутуу бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авахгүй.
- 7.9 Сонгон шалгаруулалтад орох иргэдэд шалгалтын мэдээлэл, дүгнэх журмыг урьдчилан танилцуулна.
- 7.10 Хүсэлт гаргасан иргэнийг сонгон шалгаруулахад бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулна.
- 7.11 Ажлыг хэсэг нь хөндлөнгийн хараат бус 3 гишүүн, тухайн тэнхимийн төлөөлөл 2 гишүүн нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.12 Хөндлөнгийн хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангана:
 - 7.12.1 эрдмийн зэрэгтэй байх;
 - 7.12.2 их, дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн орон тоонд ажилладаг байх;
 - 7.12.3 тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн байх.
- 7.13 Бүрэлдэхүүн сургуулийн тэнхимийн төлөөлөл дараах шаардлагыг хангана:
 - 7.13.1 эрдмийн зэрэгтэй байх;

- 7.13.2 тэнхимийн хурлаар нээлттэй санал хураалтаар сонгогдсон байх.
- 7.14 Ажлын хэсэг нь дараах бүрэн эрхтэй:
- 7.14.1 нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авах, хянах;
 - 7.14.2 хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх;
 - 7.14.3 нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх;
 - 7.14.4 нэр дэвшигч холбогдох шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ өгөх;
 - 7.14.5 шалгаруулалтын үйл явц, дүнг нийтэд мэдээлэх;
 - 7.14.6 шалгаруулалтын дүнг нийт гишүүний хуралдаанаар хэлэлцэх, ажлын хэсгийн дүгнэлт, сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу бүрэлдэхүүн салбар сургуулийн захиргаанд хүргүүлэх, хүлээлгэн өгөх.
- 7.15 Сонгон шалгаруулалтад ажиллах ажлын хэсгийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ нуун дарагдуулах, ажлын хэсэгт ажиллах явцдаа олж мэдсэн хувь хүний мэдээллийг бусдад дамжуулах, нэр дэвшигчийг ялгаварлан гадуурхах, доромжлох, сонгон шалгаруулалттай холбоотойгоор шан харамж, бэлэг дурсгал авах, мөн урьдчилан өөрийн бодол шийдвэрийг олон нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 7.16 Сонгон шалгаруулалтын бүртгэл хаагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор ажлын хэсэг хуралдаж ирүүлсэн баримт бичгийн бүрдлийг шалгана.
- 7.17 Бичиг баримтыг бүрдүүлэлтийн шаардлага хангасан иргэдийн нэрсийг МУИС-ийн цахим хуудсанд 14 хоног нээлттэй байрлуулна.
- 7.18 Сонгон шалгаруулалтын бүртгэл дууссанаас хойш 45 хоногийн дотор мэргэжлийн ур чадварын болон англи хэлний шалгалт авна.
- 7.19 Мэргэжлийн ур чадварын шалгалтыг судалгааны ажлын болон онолын мэдлэгийн түвшин, нээлттэй хичээл гэсэн 3 төрлөөр авна. Шалгалтын нийт оноо 100 байна.
- 7.19.1 *Судалгааны ажлын түвшин* (30 оноо). Тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга энэхүү журмын Хавсралт 1-ийн Хүснэгт 2 (Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг тооцох онооны шатлал)-т заасан үнэлгээний оноог ашиглаж нийт оноог дүгнэнэ. Гаргасан дүгнэлтийг МУИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээр /цаашид ЭШХН гэх/ хянан баталгаажуулна.
 - 7.19.2 *Онолын мэдлэгийн түвшин* (50 оноо). Онолын мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын агуулгыг сонгон шалгаруулалтын зард бичигдсэн шаардлагад нийцүүлэн тухайн ажлын хэсэг боловсруулан шалгаж дүгнэнэ.
 - 7.19.3 *Нээлттэй хичээл* (20 оноо). Сонгон шалгаруулалтын зард тавигдсан шаардлагын хүрээнд ажлын хэсэг нээлттэй хичээлийн 3-5 сэдэв бэлтгэнэ. Сонгон шалгаруулалтад оролцогч сэдвүүдээс сонгон, сонгосон сэдвийн хүрээнд 20 минут хичээл заана. Оноог ажлын хэсгийн гишүүдийн онооны дунджаар тооцно.
- 7.20 Англи хэлний шалгалтыг олон улсын эрх бүхий байгууллага авна.
- 7.21 Олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэдэг түвшин тогтоох шалгалтын (TOEFL, IELTS, TOEIC зэрэг) 60 ба түүнээс дээш хувийн оноотой бол тооцуулж болно.
- 7.22 Гадаад хэлний багш авах тохиолдолд англи хэлнээс гадна монгол хэлний нэмэлт шалгалт авна.
- 7.23 Мэргэжлийн ур чадвар, англи хэлний шалгалтад тэнцсэн иргэнээс нээлттэй ярилцлагыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, ёс зүйн зөвлөх, тухайн тэнхимийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй явуулна. Ярилцлагыг хангалттай эсвэл хангалтгүй гэсэн хэлбэрээр үнэлж дүгнэлтийг ажлын хэсэгт хүлээлгэж өгнө.
- 7.24 Ажлын хэсгийн саналд үндэслэн сонгон шалгаруулалтаар тэнцсэн иргэнийг МУИС-ийн захирлын тушаалаар ажилд томилно.

Б. Өндөр мэргэшсэн эрдэмтнийг ажиллуулах

- 7.25 Тухайн салбартаа эрдэм шинжилгээний бүтээлээрээ олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллуулж болно.
- 7.26 Өндөр мэргэшсэн эрдэмтэн дараах шаардлагыг хангана:
- 7.26.1 судалгааны төсөл, хөтөлбөр удирдаж хэрэгжүүлсэн байх;
 - 7.26.2 дэд профессор, профессор зэрэглэлийн эрдэм шинжилгээний хэсэгт харгалзах оноог Хавсралт 1-ийн Хүснэгт 1 дэх дэд профессорын зэрэглэл ахих онооны 70%,

- профессорын зэрэглэл ахих онооны 80%-ийг судалгааны бүтээлүүдээрээ (Хавсралт 1-ийн Хүснэгт 2) тооцуулсан байх;
- 7.26.3 нийгэм хүмүүнлэгийн салбарт сүүлийн 5 жилд Web of Science IF-JCR болон Scopus-ийн индекстэй мэргэжлийн салбарын дунджаас дээш эрэмбэтэй сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор 3-аас цөөнгүй өгүүллийг хэвлүүлсэн байх эсвэл мэргэжлийн түвшинд хянагддаг (peer-review) англи хэл дээр хэвлэгддэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор 5-аас цөөнгүй өгүүлэл болон нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн байх;
- 7.26.4 байгалийн ухааны салбарт сүүлийн 5 жилд Web of Science IF-JCR индекстэй олон улсын мэргэжлийн салбарын дунджаас дээш эрэмбэтэй сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор 3-аас цөөнгүй өгүүллийг хэвлүүлсэн байх.
- 7.27 Өндөр мэргэшсэн эрдэмтнийг урьж ажиллуулах үйл ажиллагаа дараах үе шаттай байна:
- 7.27.1 Энэхүү журмын 7.26-д заасан шаардлагыг хангасан иргэнийг урьж ажиллуулах талаар тухайн мэргэжлийн тэнхимийн хамт олны хэлэлцсэн саналыг харьяа бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүргүүлнэ.
- 7.27.2 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаа нь урих багшийн шаардлагад үндэслэн элсэлт бүртгэл болон хөтөлбөр хариуцсан нэгжээс дараах мэдээллийг авч дүгнэлт гаргана:
- 7.27.2.1 МУИС-ийн багшлах хүний нөөцийн төлөвлөгөө;
- 7.27.2.2 өмнөх 2 хичээлийн жилийн дөрвөн улиралд тухайн багшийн заах мэргэжлийн хичээлийн гүйцэтгэл;
- 7.27.2.3 тухайн тэнхимийн багш нарын цагийн гүйцэтгэл,
- 7.27.2.4 бусад бүрэлдэхүүн сургуулийн ижил мэргэжлийн багш нарын цагийн ачаалал
- 7.27.3 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн шийдвэр, холбогдох баримт бичгийн хамт ЗХНХН-д хүргүүлнэ.
- 7.27.4 Бүрэлдэхүүн сургуулийн шийдвэрт үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар ажилд томилно.
- 7.28 Уригдсан эрдэмтнээр их сургуулийн судалгааны бүтцийг ашиглан хамтарсан эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх, танхимын болон цахим хэлбэрээр хичээл заалгаж болох ба тухайн эрдэмтэн гадаадын нэр хүндтэй их дээд сургуульд багшилж байгаа тохиолдолд, урихаар санал гаргасан, мэргэжлийн тэнхимд давхар харьяалалтай байж болно.
- 7.29 Давхар харьяалалтай ажиллах уригдсан эрдэмтнийг тэнхимийн цагийн ачаалал, судалгааны ажлын цар хүрээнээс хамааран тодорхой хувиар гэрээ байгуулан ажиллуулж болно.

Найм.Багш нарын хичээлийн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ

- 8.1. Багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч нэг хичээлийн жилд гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээ болон нийгмийн үйлчилгээний ажил нь дараах багц цагийн хэмжээтэй байна:

Албан тушаалын зэрэглэл	Сургалт “А” (ББц)	Эрдэм шинжилгээ “Б” (ББц)	Бусад ажил “В” (ББц)
Профессор	12	10	4
Дэд профессор	13	8	5
Ахлах багш	15	6	5
Багш	16	5	5

- 8.2. Багшийн ажлыг багшийн багц цаг (ББц)-аар үнэлэх ба дээрх “А, Б, В” ажлын нийт хэмжээ нэг хичээлийн жилд 26 ББц байна.
- 8.3. Биеийн тамирын тэнхим, Гадаад хэлний төвийн докторын зэрэггүй ахлах багш, багшийн зэрэглэлд ажиллаж буй багш нэг хичээлийн жилд сургалтын 18 багц цагийг биелүүлнэ. Энэ үед эрдэм шинжилгээний багц цагийн ногдлыг 3 ББц болгон бууруулна.
- 8.4. МУИС-ийн зорилтот орон тоонд ажиллаж буй профессорын тухайн хичээлийн жилийн “А” болон “Б” цагийн ногдлын харьцаанд өөрчлөлт оруулах тохиолдолд Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 8.5. Ерөнхий суурь хичээл заадаг багш, ахлах багш Хөдөлмөрийн гэрээний дагуу эрдэм шинжилгээний ажлын ногдлыг сургалтын үйл ажиллагаагаар шилжүүлэн гүйцэтгэж болно.

- 8.6. Давхар харьяалалтай ажиллаж байгаа багш үндсэн тэнхимдээ “А” цагийн ногдлын 50-аас дээш хувийг биелүүлсэн байна.
- 8.7. МУИС-д судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж цалингийнхаа тодорхой хувийг төслөөсөө санхүүжүүлж байгаа нөхцөлд түүнтэй дүйцүүлэн “А” цагийн ногдлыг хорогдуулан тооцуулж болно. Энэ тохиолдолд тухайн зэрэглэлдээ бүтэн ачааллаар ажилласан гэж үзнэ.
- 8.8. Тэнхимийн эрхлэгчийн нэг хичээлийн жилд гүйцэтгэх сургалтын цагийн ногдлыг 3 ББц-аар хөнгөлнө.
- 8.9. Тэнхимийн эрхлэгч илүү цаг заахыг хориглоно.
- 8.10. 0-3 насны хүүхэдтэй багшид нэг хичээлийн жилд гүйцэтгэх “В” цагийн ногдлыг 50 хүртэл хувь хөнгөлнө.

Ес. Багшийн сургалтын ажлын гүйцэтгэлийг тооцох

- 9.1. Сургалтын үйл ажиллагаа нь сургалтад бэлтгэх, танхимын сургалт, зөвлөгөө өгөх болон суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд нийт 48 цагийг 1 Багшийн Багц цаг (ББц) гэж ойлгоно:

No	Сургалтын хэлбэр	Сургалтад бэлтгэх	Танхимын сургалт	Суралцагчид зөвлөгөө өгөх	Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх	Нийт цаг
1	Лекц (бакалаврын)	12	16	6	14	48
2	Семинар, лаборатори (бакалаврын)	8	32	4	4	48
3	Лаборатори (бакалаврын)	0	48	0	0	48
4	Лекц (ахисан түвшин)	16	12	10	10	48
5	Семинар (ахисан түвшин)	8	24	8	8	48

- 9.2. Сургалтад бэлтгэхэд сургалтын хөтөлбөр, хичээлийн тодорхойлолт боловсруулах, сургалтын материал, цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлдэх, тест, шалгалтын сэдэв боловсруулах зэрэг үйл ажиллагаа багтана.
- 9.3. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэхэд танхимын сургалтаас бусад цагаар реферат, гэрийн уншлага, бие даалт шалгах, явцын болон улирлын шалгалт, бусад хэлбэрээр суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх үйл ажиллагаа багтана.
- 9.4. Сургалтын хөтөлбөрт шинээр тусгагдсан хичээлийг анх удаа заасан багшийн сургалтад бэлтгэх цагийг тэнхимийн саналыг үндэслэн 30 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцож болно. Энэ үед уг хичээлийн хөтөлбөр иж бүрэн хийгдсэн эсэхийг хөтөлбөр хариуцсан нэгж, тэнхим хамтран баримтжуулна.
- 9.5. Суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн (цахим, мэдээллийн технологи, загварчлах (симуляц), асуудал шийдвэрлүүлэх, тухайлсан судалгаа), англи хэлээр хичээл заах, сургалтын шинэлэг арга барилаар заасан хичээлд бэлтгэхэд тооцох багц цагийг 50% хүртэл нэмэгдүүлж болох бөгөөд тэнхимийн саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 9.6. Бакалаврын түвшний хичээл болон магистр, докторын сургалтын ерөнхий суурь хичээлийн лекцийн хэлбэр (танхим, цахим)-ээс үл хамааран суралцагчдын тоог харгалзан, үржүүлэх коэффициент хэрэглэн ББц-ийг тооцно.
 - 9.6.1 Суралцагчийн тоо 10 хүрээгүй тохиолдолд тухайн хичээлийг заах эсэхийг улирлын эхэнд бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хуралдааны саналыг үндэслэн сургалт эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.
 - 9.6.2 Тухайн хичээлийг сонгосон суралцагчийн тооноос хамааруулан ББц-ийг дараах хүснэгтийн дагуу тооцоолно.

Суралцагчийн тоо	≤ 9	10-50	51-160	161-ээс дээш
Үржүүлэх коэффициент	0.75	1	9.6.3 заалт дахь томъёогоор	1.5

9.6.3 Тухайн хичээл сонгосон оюутны тоо нь 51-160 хооронд бол үржүүлэх коэффициентийг дараах томъёогоор тооцоолно:

$$1 + 0.004 \times (\text{Хичээл сонгосон оюутны тоо} - 50).$$

9.6.4 31-40 хүртэл суралцагчтай семинарын хичээлийн үржүүлэх коэффициентийг дараах томъёогоор тооцоолно:

$$1 + 0.005 \times (\text{Хичээл сонгосон оюутны тоо} - 30).$$

9.7. Магистр, докторын сургалтын мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн заасан багшийн багц цагийг танхим болон цахим хэлбэрээс үл хамааран дор дурдсан байдлаар үржүүлэх коэффициент ашиглан тооцоолно:

Суралцагчийн тоо	≤ 3	3-10	11-60	61-ээс дээш
Үржүүлэх коэффициент	0.75	1	9.7.2 заалт дахь томъёогоор	1.3

9.7.1 Суралцагчийн тоо 3 хүрээгүй тохиолдолд тухайн хичээлийг заах эсэхийг улирлын эхэнд бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хуралдааны саналыг үндэслэн сургалт эрхэлсэн дэд захирал шийдвэрлэнэ.

9.7.2 10-аас дээш суралцагчтай хичээлийн үржүүлэх коэффициентийг дараах томъёогоор тооцоолно:

$$1 + 0.006 \times (\text{Хичээл сонгосон оюутны тоо} - 10).$$

9.8. Бакалаврын сургалтын хичээлийн семинарын бүлгийг дунджаар 25 буюу 20-30 суралцагчаар, биеийн тамирын хичээлийн бүлгийг 40 суралцагчаар тус тус зохион байгуулна.

9.9. Лабораторийн хичээлийн бүлэгт хамрагдах суралцагчийн тоог лабораторийн багтаамж, хүчин чадлыг бүрэн ашиглахуйц хэмжээгээр тогтооно. Байгалийн ухааны болон компьютер, лингафоны лабораториудыг чөлөөт цагийн хуваарьт шилжүүлж ажиллуулахыг зөвшөөрнө.

9.10. Хээрийн болон багшлах дадлагад 8 суралцагчийг 2 долоо хоног удирдсан багшид сургалтын 1 ББц, үйлдвэрлэлийн дадлага удирдахад мөн хугацаанд 15 суралцагчид 0.5 ББц, мэргэжлийн магистрын мэргэжих дадлага удирдахад мөн хугацаанд 10 суралцагчид 0.5 ББц, танилцах дадлага удирдсан болон багшлах дадлага удирдсан боловсрол, сэтгэл судлалын багш нарын хувьд мөн хугацаанд 30 суралцагчид 0.5 ББц тооцно.

9.11. Багш хичээлийн улирал бүрийн эхэнд суралцагчдад зөвлөгөө өгөх, судалгааны ажилд зарцуулах хуваарийг нэгжийн удирдлагаар батлуулж мөрдөнө.

Багц цагаар үл хэмжигдэх сургалтын үйл ажиллагаа

9.12. Тодорхой хичээлийн багц цагийн үнэлгээнд оруулах боломжгүй үйл ажиллагааг цагаар тооцож хөлс олгоно. Нэг цагийн үнэлгээг тогтоох болон элсэлт, гадаад хэлний нэгдсэн шалгалтын комиссад ажлын хөлс олгохыг МУИС-ийн захирлын тушаалаар, дараах ажилд хөлс олгохыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

9.11.1 *Комиссын бүрэлдэхүүнтэй шалгалт авах.* Хөндлөнгийн, батлах, элсэлтийн, гадаад болон монгол хэлний нэгдсэн шалгалт авах, суралцагчийн судалгааны ажил хамгаалуулах комиссын гишүүдэд зохих тушаалаар хөлс олгох цагийг дараах жишгээр тооцно:

	Шалгалтын төрөл	Бүлгийн хэмжээ	Тооцох цаг
1	Бакалаврын сургалтын хөндлөнгийн болон батлах шалгалт авсан комиссын гишүүд	30 хүнтэй бүлэгт 30-аас дээш хүн бүрт	3.0 0.1

2	Магистр, докторын элсэлтийн шалгалт авсан комиссын гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.4
3	Магистр, докторын гадаад болон монгол хэлний нэгдсэн шалгалт бичгээр авсан комиссын гишүүд	30 хүнтэй бүлэгт 30-60 хүнтэй бүлэгт 60-аас дээш хүнтэй бүлэгт	3.0 4.0 5.0
4	Тестийн шалгалтын сэдэв боловсруулах	2 хувилбартай нэг шалгалтын тест	4.0

9.11.2 Бакалаврын төгсөлттэй холбоотой ажил:

Гүйцэтгэх ажил	Ажлын хэмжээ	Тооцох цаг
Бакалаврын ажил хамгаалуулах комиссын нарийн бичгийн дарга	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.5 0.4
Бакалаврын ажил хамгаалуулах комиссын дарга, гишүүн	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.0 0.3
Бакалаврын ажил удирдсан багш	1 ажил	20.0
Бакалаврын ажилд шүүмж бичсэн багш	1 ажил	3.0

9.11.3 Магистрын төгсөлттэй холбоотой ажил:

Гүйцэтгэх ажил	Ажлын хэмжээ	Тооцох цаг
Магистрын урьдчилсан хамгаалалтын 3-7 гишүүнтэй комиссын дарга, гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.3
Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.5 0.4
Магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд	5 хүртэл хүнтэй бүлэгт 5-аас дээш хүн бүрт	2.0 0.4
Магистрын ажлын шүүмж бичсэн багш	1 ажил	6.0
Магистрын ажил удирдсан багш	1 ажил	48.0
Мэргэжлийн магистрын дадлага хамгаалуулах комиссын гишүүн	10 хүртэл хүнтэй бүлэгт 10-аас дээш хүн бүрт	2.0 0.2

9.11.4 Докторантын төгсөлттэй холбоотой ажлын хэсэг, удирдагч шүүмжлэгчид тооцох цаг:

Гүйцэтгэх ажил	Ажлын хэмжээ	Тооцох цаг
Докторын ажил урьдчилсан хамгаалуулах комиссын дарга, гишүүд (10-15 хүн)	1 докторант	2.0
Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга	1 докторант	5.0
Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд	1 докторант	3.0
Докторын ажил удирдсан багш	1 докторант	72.0
Докторын ажлын шүүмж бичсэн багш	1 докторант	9.0
Докторын ажлын зөвлөхөөр ажилласан багш	1 докторант	8.0

Арав. Багшийн эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох

10.1 Б1. Эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлд тооцох багц цаг:

No	Сэтгүүлийн төрөл	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	Web of Science IF-JCR (Science Citation Index Expanded, Social Sciences Citation Index) индекс бүхий мэргэжлийн сэтгүүл: Б.1.1.1 тухайн судалгааны салбарын дундаж болон түүнээс дээгүүр индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл;	1 өгүүлэл	10.0 ББц

	Б.1.1.2 дунджаас доогуур индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл;		8.0 ББц
2	Scopus-ын индекстэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл: Б.1.2.1 тухайн судалгааны салбарын дундаж болон түүнээс дээгүүр индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл; Б.1.2.2 дунджаас доогуур индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл;	1 өгүүлэл	10.0 ББц 8.0 ББц
3	Web of science Emerging Sources Citation Index (ESCI) болон Art & Humanities Citation Index (АНЦИ) индекстэй сэтгүүл;	1 өгүүлэл	6.0 ББц
4	Бүртгэлгүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг (peer-review) гадаад хэл дээр хэвлэгддэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүл;	1 өгүүлэл	4.0 ББц
5	МУИС-д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, англи хэлээр хэвлэгддэг, олон улсын редакцын зөвлөл бүхий дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл;	1 өгүүлэл	3.0 ББц
6	МУИС-д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, монгол, англи хэлээр холимог хэлбэрээр болон монгол хэлээр хэвлэгддэг, мэргэжлийн түвшинд хянагддаг дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл;	1 өгүүлэл	2.0ББц

- 10.1.1. Олон улсын мэргэжлийн сэтгүүлийн дундаж индексийг жил бүр ЭШХН холбогдох мэдээллийн сангаас авч бүрэлдэхүүн сургуулиудад мэдээлнэ.
- 10.1.2. Дотоодод хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн ангиллын жагсаалтыг хичээлийн жилийн эцэст, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөс томилогдсон ажлын хэсэг ажиллан үр дүнг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ. Эрдмийн зөвлөлийн хурлаар батлагдсан сэтгүүлүүдийн жагсаалтыг ЭШХН-д хүргүүлнэ. ЭШХН нь сэтгүүлүүдийн жагсаалтыг Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем (ЭШММС)-д нээлттэй байршуулна.
- 10.1.3. Б1 хүснэгт дэх хэвлэгдсэн өгүүлэлд багшийн багц цагийг нэгдүгээр зохиогчид 1.0, холбоо баригч зохиогчид 0.8, бусад зохиогчид 0.5-аар үржүүлж тооцно.
- 10.1.4. Өгүүлэл нь хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) тохиолдолд багц цаг тооцож болно.
- 10.1.5. Өгүүллийг зохиогчийн зөвшөөрснөөр дараагийн хичээлийн жилийн ажлын үнэлгээнд нь тооцож болно. Үүнээс бусад тохиолдолд өмнөх онуудад хэвлүүлсэн өгүүллийг үнэлгээнд тооцохгүй.

10.2 Б2. Эрдэм шинжилгээний хуралд оролцоход тооцох багц цаг:

No	Хурлын төрөл	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	Web of Science болон Scopus индекс бүхий мэргэжлийн сэтгүүлийн тусгай дугаар гаргадаг олон улсын мэргэжлийн нийгэмлэгийн хурал: - уригдсан илтгэл; - аман илтгэл; - үзүүлэн илтгэл.	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	4.0 ББц 3.0 ББц 2.0 ББц
2	Олон улсын хурал: - уригдсан илтгэл; - аман илтгэл; - үзүүлэн илтгэл.	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	3.0 ББц 2.0 ББц 1.5 ББц
3	Улсын хэмжээнд: - уригдсан илтгэл; - аман илтгэл; - үзүүлэн илтгэл.	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	1.8 ББц 1.5 ББц 1.0 ББц

- 10.2.1. 5-аас доошгүй улсын судлаачид оролцсон эрдэм шинжилгээний хурлыг олон улсын хурал гэж үзнэ. 2-4 улсын судлаачид оролцсон байвал улсын хэмжээний хуралтай дүйцүүлнэ.
- 10.2.2. Хуралд оролцож буй байгууллагын тоо 3-аас олон бол улсын хэмжээний хурал гэж үзнэ.
- 10.2.3. Хүснэгт Б2 дахь хурлын илтгэлд харгалзах багц цагийг үндсэн илтгэгчид бүтнээр, бусад илтгэгчид дээрх хүснэгт дэх харгалзах багц цагийг тэнцүү хувааж тооцно.

10.3 Б3. Хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлд тооцох багц цаг:

No	Эрдэм шинжилгээний бүтээл	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	Монограф буюу нэг сэдэвт бүтээл: - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн; - хамгаалсан диссертаци;	1 бүтээл	30.0 ББц 12.0 ББц 6.0 ББц 4.0 ББц
2	Нэг сэдэвт хамтын бүтээл: - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн.	1 бүлэг	10.0 ББц 4.0 ББц 2.0 ББц
3	Сурах бичиг: - ерөнхий суурь хичээлийн; - бакалаврын мэргэжлийн болон ахисан түвшний хичээлийн; - гадаад хэлээр бичигдсэн; - зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй орчуулгын сурах бичиг; - сургалтын гарын авлага.	1 х.х	0.8 ББц 1.0 ББц 1.2 ББц 1.0 ББц 0.2 ББц
4	Эх бичгийн цогц судалгаа	1 х.х	0.4 ББц
5	Сурвалжийн эрдэм шинжилгээний орчуулга	1 х.х	0.4 ББц
6	Архивын баримтын эмхэтгэл	1 х.х	0.4 ББц
7	Хэлний толь бичиг	1 х.х	0.3 ББц
8	Нэвтэрхий толь бичиг	1 х.х	0.3 ББц
9	Нэр томъёоны толь бичиг	1 х.х	0.3 ББц

- 10.3.1. Хүснэгт Б3 дахь эрдэм шинжилгээний бүтээлүүдийг бүрэлдэхүүн/ салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж багц цаг тооцох эсэхийг шийдвэрлэнэ.
- 10.3.2. Эрдэм шинжилгээний бүтээл нь хамтынх байвал зохиогчдын оролцоог хэвлэлийн хуудсаар тодорхойлно. Тодорхойлох боломжгүй тохиолдолд багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно.
- 10.3.3. Ном, сурах бичиг гэх мэт хэвлэмэл бүтээгдэхүүний хэвлэлийн хуудсыг тогтоохдоо нүүр, гарчиг, зохиогчийн үг зэргийг хуудасны тоонд оруулахгүй.
- 10.3.4. Сурах бичгийг дахин хэвлүүлж байгаа тохиолдолд зөвхөн нэмэгдсэн агуулгад харгалзах хэсэгт багц цаг тооцно.
- 10.3.5. Орчуулгын бүтээлд оюуны өмчийн зөвшөөрөлтэй байхыг шаардана.

10.4 Б4. Оюуны өмчийн бүтээл:

	Оюуны өмчийн төрөл	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	Шинэ бүтээлийн патент: (зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан):		

	- гадаадад - дотоодод	1 бүтээл	8.0 ББц 3.0 ББц
2	Бүтээгдэхүүний загвар (зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан): - гадаадад - дотоодод	1 бүтээл	3.0 ББц 1.0 ББц

10.5 Б5. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын үнэлгээ:

	Төслийн төрөл	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	ШУТС-ийн санхүүжилттэй төсөл ба грант	1 төсөл	10.5.3 заалт дахь томьёоны дагуу тооцно.
2	Төрийн байгууллага, олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, грант, захиалгат судалгаа	1 төсөл	
3	Аж үйлдвэр, компани, хувь хүн болон бусад эх үүсвэр	1 төсөл	

- 10.5.1 Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил нь МУИС-ийн дансаар шилжүүлэг орж захиран зарцуулсан байна.
- 10.5.2 Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж МУИС-д оруулсан мөнгөн болон материаллаг орлогоо багц цагт тооцуулахгүй тохиолдолд түүнд урамшуулал олгох асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 10.5.3 Багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын ББц-ыг дараах томьёогоор тооцно:

ББц-ын хэмжээ=(Төслийн нийт санхүүжилт) / 3 сая төгрөг.

- 10.5.4 Төсөл, гэрээт ажлын нийт ББц-ийг төслийн удирдагч төслийн багийн гишүүдэд хуваарилж, хичээлийн жил бүрт МУИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн системд бүртгүүлнэ.

10.6 Б6. Эрдэм шинжилгээний бусад ажилд харгалзах багц цаг:

	Эрдэм шинжилгээний ажил	Хэмжих нэгж	Тооцох ББц
1	Эрдэм шинжилгээний их семинарт илтгэл тавих	1 илтгэл	0.5 ББц
2	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн: - МУИС-д бүртгэлтэй дотоодын сэтгүүл - гадаадын сэтгүүл	1 хич. жил	0.5 ББц 1.0 ББц
3	Салбар/профессорын мэргэжлийн семинар: - удирдах (12-оос доошгүй явуулсан байх) - илтгэл тавих (1 удаа)	1 хич.жил 1 удаа	0.5 ББц 0.2 ББц
4	Эрдэм шинжилгээний бүтээл редакторлах: - мэргэжлийн сурах бичиг - монограф - орчуулгын бүтээл	1 х.х	0.2 ББц 0.2 ББц 0.3 ББц
5	Хууль, үзэл баримтлал, салбарын зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажиллах:	1 баримт бичиг	2.0 ББц
6	Боловсруулж батлуулсан стандарт /MNS/	1 стандарт	1.5 ББц
7	Шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээ	1 анализ	0.4 ББц

8	Суралцагчдыг удирдаж эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх (давхардуулж тооцохгүй.): - олон улсад (шагнал авбал); - улсад (шагнал авбал) - илтгэл	1 илтгэл	1.0 ББц 0.5 ББц 0.2 ББц
---	---	----------	-------------------------------

- 10.6.1. Хүснэгт Б6-ийн 3 дугаар мөрөн дэх профессорын семинарын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд тэнхимийн эрхлэгчээр батлуулна. Нэг хичээлийн жилд 12-оос доошгүй удаа семинар явуулсан байна.
- 10.6.2. Хүснэгт Б6-ийн 4 дүгээр мөрөн дэх эрдэм шинжилгээний бүтээл редакторлоход зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, тодорхойгүй бол бүх багц цагийг оролцогчдод тэнцүү хувааж тооцно.
- 10.6.3. Хүснэгт Б6-ийн 5 дугаар мөрөн дэх ажлын хэсэгт орж ажилласныг тухайн ажлыг санаачлагч, ажлын хэсгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, УИХ-ын тамгын газраас ажлын хэсэгт орж ажиллах тушаал, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, үр дүнг тодорхойлсон бичгийн дагуу дүгнэнэ.
- 10.6.4. Хүснэгт Б.6-ийн 7 дугаар мөрөн дэх шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний үр дүнг судалгааны өгүүлэл бичих шаардлагын дагуу гүйцэтгэсэн байна.
- 10.6.5. Суралцагчийг удирдаж илтгэл тавиулахад тооцсон ББц-ийг, багш энэ журмын 10.2 заалтын дагуу авах ББц-тай давхцуулж тооцохгүй.
- 10.6.6. Боловсруулж батлуулсан стандарт нь нэгээс олон зохиогчтой бол ББц-ыг бүх оролцогчдод тэнцүү хуваана.
- 10.7 Багшийн ажлыг тооцох дээрх үзүүлэлтэд тусгагдаагүй эрдэм шинжилгээний бусад ажлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн онол, практикийн ач холбогдол, хөдөлмөр зарцуулалтыг харгалзан 1 ББц-аас дээшгүй хэмжээгээр үнэлэн багц цаг тооцно.

Арван нэг. Бусад ажил

В. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ

- 11.1 Сургуулийн удирдлага, зохион байгуулалт, суралцагчдын төлөвшил, соёл, олон нийтийн ажил, нийгэмд үйлчлэх чиглэлээр багшийн хийсэн дараах ажлуудад харгалзах багц цаг тооцно.

	Ажлын төрөл	Ажлын хэмжээ, хугацаа	Тооцох ББц
1	Лаборатори, кабинет хариуцан ажиллах	1 хич. жил	1.0 ББц
2	Тэнхимийн даалгавраар багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх	1 цаг	0.5 ББц
3	Сургуулийн захиргааны шийдвэрээр ² : - сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох, заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах зэрэг үүрэгт ажилд оролцох; - тэнхимийн хурлын шийдвэрээр тэнхимийн ажил гүйцэтгэх.	1 удаа	Тушаалаар нэг ажилд 1ББц-аас ихгүй 0.5 ББц-аас ихгүй
4	Олимпиад уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах: - олон улсын хэмжээнд; - улсын хэмжээнд;	1	2.0 ББц 1.5 ББц

²Тушаалаар тухайн үүрэгт ажлын хэлс олгогдсон тохиолдолд багц цаг давхардуулж тооцохгүй.

	- сургуулийн хэмжээнд; - бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэмжээнд.	арга хэмжээ	1.0 ББц 0.5 ББц
5	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил: - зөвлөх багш; - соёл, олон нийтийн ажил зохион байгуулах.	1 хич. жил 1 арга хэмжээ	1.0 ББц 0.5 ББц
6	Эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1.0 ББц
7	Олон улсын хурал, семинар зохион байгуулах	1 хурал	2.0 ББц
8	Улсын хэмжээний хурал зохион байгуулах	1 хурал	1.0 ББц
9	Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа: - телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;	1 нэвтрүүлэг	1.0 ББц
	- өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих;	1 нийтлэл	0.5 ББц
	- үндэсний зөвлөхөөр ажиллах.	1 удаа	1.0 ББц
10	МУИС-ийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн (давхардуулж тооцож болно)	1 хич. жил	1.0 ББц
11	Мэргэжлийн холбоодыг удирдан зохион байгуулах, тэргүүлж ажиллах	1 хич. жил	1.0 ББц
12	Тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрлөөр суралцагчдад зориулсан дугуйлан, клуб ажиллуулах	1 хич. жил	1.0 ББц
13	Хөтөлбөрийн хороонд гишүүнээр ажиллах (давхардуулж тооцож болно)	1 хич. жил	1.0 ББц

Арван хоёр. Багшийн цагийн ногдлыг төлөвлөх, гүйцэтгэлийг дүгнэх, хянах

- 12.1. Хичээлийн жилийн намрын улиралд гүйцэтгэх нийт сургалтын ажлыг өмнөх хичээлийн жилийн хаврын улиралд 5-р сард, хаврын улирлыг намар 12-р сард сургалтын хөтөлбөр, суралцагчдын хувийн төлөвлөгөөнд үндэслэнэ.
- 12.2. Багш нарын цагийн ногдлыг тэнхимийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргана.
- 12.3. Тэнхимийн эрхлэгч багш нарын сургалтын цагийг жигд хуваарилсан байх шаардлагатай бөгөөд багш хүрэлцэхгүй тохиолдолд тухайн тэнхимийн багштай тохиролцож нэмэлт цагийн ачаалалтай ажиллуулж болно. Багшийн заах нэмэлт цагийн ачаалал нь тухайн багшийн ажиллаж буй зэрэглэлийн ногдлын 40% -аас хэтрэхгүй.
- 12.4. Багш нэмэлт цагаар заах тохиолдолд бүрэлдэхүүн/ салбар сургуулийн захиралтай Хавсралт гэрээ байгуулна. Хавсралт гэрээ нь Хөдөлмөрийн гэрээний адил хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.5. Гэрээнд хичээлийн нэр, багц цаг, заах улирлыг тодорхой тусгасан байна.
- 12.6. Хичээлийн жилийн явцад өвдсөн, ажлаас өөрчлөгдсөн, гадаад, дотоодод томилолтоор ажилласан багшийн хичээлийг тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн, нэмэлт цаг гүйцэтгүүлж болно.
- 12.7. Сургалт хариуцсан нэгжийн удирдлага бусад сургуулийн багштай тохиролцож хичээл заалгах, цагийн багшийн журмаар ажиллуулахыг хориглоно.
- 12.8. Сургууль хоорондын тооцоог суралцагчийн багц цагт үндэслэн хийх бөгөөд тухайн хичээлийн жилийн нийт багц цагийн тооцоог сургалт хариуцсан нэгж нэгтгэн хянаж, санхүү хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 12.9. Багш хичээлийн жилийн төгсгөлд “А” цагийн гүйцэтгэлийн тайланг сургалт удирдлагын СиСи системээс баталгаажуулж, тэнхимийн эрхлэгчид хүлээлгэж өгнө.
- 12.10. Багшийн сургалтын цагийн гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч нягтлан нэгтгэснийг сургалт хариуцсан нэгжийн удирдлага хянаж бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүргүүлнэ.
- 12.11. Багш тухайн хичээлийн жилийн “Б”, “В” цагийн гүйцэтгэлийг Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн систем (ЭШММС)-д оруулна.

- 12.12. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан, эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг хянаж ЭШММС-д баталгаажуулна.
- 12.13. Багш тухайн хичээлийн жилд тооцуулах багц цагийг зөвшөөрснөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний багц цаг баталгаажна.
- 12.14. Багшийн "В" цагийн гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч хянан баталгаажуулна.
- 12.15. Багш СиСи системээс тухайн хичээлийн жилийн өөрийн нийт ("А, Б, В") ажлын гүйцэтгэлийн тайланг баталгаажуулж, тэнхимийн эрхлэгчид хүлээлгэж өгнө. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал нь тэнхим тус бүрийн багш нарын нийт гүйцэтгэлийг хянаж баталгаажуулна.
- 12.16. Багшийн ажлын гүйцэтгэлд "А", "Б" цагийн аль нэг дутвал илүү хэсгийн 1.5 ББц-ийг дутуу хэсгийн 1 ББц-тай дүйцүүлэн шилжүүлж тооцно.
- 12.17. Багшийн ажлын гүйцэтгэлийн "В" хэсэгт ББц дутвал "А", "Б"-ийн гүйцэтгэлийн 1ББц-ийг "В" хэсгийн 2ББц-т дүйцүүлэн шилжүүлнэ.
- 12.18. Нэмэлт цагийн хөлс олгох нөхцөл:
 - 12.18.1. "А", "Б", "В" цагийн ачаалал тус тусдаа биелэгдсэн нөхцөлд "А"-ын нэмэлт цагийн хөлс олгоно. Б-ээс А-д цаг шилжүүлэн нэмэлт цаг гаргахыг зөвшөөрөхгүй ба түүнд хөлс олгохгүй.
 - 12.18.2. "А", "Б", "В" цагийн цагийн ачаалал тус тусдаа биелсэн, мөн Б-ийн ачааллыг Б1.1 болон Б1.2-оор бүрэн биелүүлж давсан тохиолдолд давсан гүйцэтгэлд, тухайн багшийн зэрэглэлийн "Б", цагийн ачааллын 30 хүртэл хувьд нэмэлт цаг тооцно.
- 12.19. Багшийн сургалтын ажлын (А) цагийн ногдлыг давуулан гүйцэтгэсэн бол нэмэлт ББц-ийн хөлсийг дараах аргачлалаар тооцно:
 - 12.19.1. Ачааллын 40 хүртэлх хувийн нэмэлт багц цагийн хөлсийг "үндсэн үнэлгээ"-гээр тооцно. Нэг багц цагийн "үндсэн үнэлгээ"-г багш зэрэглэлийн дунд шатлалын үндсэн цалингийн гуравны нэгээр тооцно. Зөвлөх багш нарын нэмэлт цагийн "үндсэн үнэлгээ" үндсэн багшийн үнэлгээтэй адилаар тооцно.
 - 12.19.2. Багшийн эрдэм шинжилгээний ажлын "Б" цагийн ногдлоос илүү гүйцэтгэсэн (энэхүү журмын 12.18.2 дахь заалтыг үндэслэн) нэмэлт цагийн хөлсийг 1 ББц-д багшийн тухайн зэрэглэлийн үндсэн цалингийн гуравны нэг байхаар тооцно.
- 12.20. Бүрэлдэхүүн сургууль багш нарын ажлын гүйцэтгэлийн нэгдсэн дүнг ЗХНХН- д хүргүүлнэ.
- 12.21. ЗХНХН нь багш нарын ажлын гүйцэтгэлийг хянаж, шаардлагатай тохиолдолд мониторинг хийж, үр дүнг МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж ээлжийн амралт олгоно.
- 12.22. Багшийн ажлын "А", "Б" цагийн аль нэгийг дутуу биелүүлсэн тохиолдолд дутсан багц цагт ногдох цалинг буцаан төлүүлэх эсвэл ээлжийн амралтын олговроос суутгана.

Арван гурав. Багшийн ажлын нэгдсэн үнэлгээ хийх, зэрэглэлд шалгаруулах

- 13.1. МУИС-ийн багш нь ажлын нэгдсэн үнэлгээнд 3 жил тутамд хамрагдана. Багшийн ажлыг хугацаат үнэлгээний зарчмыг баримталж үнэлнэ.
- 13.2. Бүрэлдэхүүн/салбар сургуулиуд сүүлийн 3 жилд багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах албан тушаалын зэрэглэлийг тогтооно.
- 13.3. Зэрэглэлийн шалгаруулалтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд багш харгалзах шалгуурын дагуу материалаа бүрдүүлнэ:
 - 13.3.1 зэрэглэл ахих;
 - 13.3.2 зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллах;
 - 13.3.3 зэрэглэл баталгаажуулах.
- 13.4. Зэрэглэлийн шалгаруулалтыг тухайн хичээлийн жилийн хаврын улиралд (6 дугаар сарын 15-ны дотор) явуулж, дараагийн хичээлийн жилээс (9 дүгээр сарын 01-ээс) мөрдөнө.
- 13.5. Багш дараагийн зэрэглэл ахиж ажиллахын тулд энэхүү журмын 6-р бүлэгт заасан харгалзах зэрэглэлийн шаардлага болон эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийн үйлчилгээний чиглэлээр Хавсралт 1-ийн Хүснэгт 1.1-д заасан тухайн зэрэглэлд ахих оноог хангасан байна.

- 13.6. Хүснэгт 1 ба 1.1-д заасан оноо нь эрдэм шинжилгээ болон сургалт, нийгмийн үйлчилгээний чиглэлээр багшийн тооцож болох бүх ажлын онооны нийлбэр байна.
- 13.7. Багшийн зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 13.7.1 энэхүү журмын Хүснэгт 1-ийн 2-р мөрөн дэх (Хавсралт 1) багшийн зэрэглэлд харгалзах оноог биелүүлсэн байх;
 - 13.7.2 сүүлийн 3 жилд ахисан нийт онооны 40 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны хэсэгт (Хүснэгт-2 оноогоор тооцогдох) тооцогдсон байх.
- 13.8. Багш дараагийн зэрэглэлд ахиж ажиллахад дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:
 - 13.8.1 магистрын зэрэгтэй бол докторын зэрэг хамгаалсан байх;
- 13.9. Ахлах багшийн зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 13.9.1 ахлах багшийн зэрэглэлд энэхүү журмын Хүснэгт 1-ийн 2-р мөрөн дэх (Хавсралт 1) оноог биелүүлсэн байх;
 - 13.9.2 ахицын онооны 50 хувиас доошгүй хувь нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны (Хүснэгт-2 дахь оноогоор тооцогдох) онооны үзүүлэлтээр гүйцэтгэгдсэн байх;
- 13.10. Ахлах багшийн зэрэглэл ахих нөхцөлд дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:
 - 13.10.1 сургалтын гарын авлага хэвлүүлж МУИС-ийн цахим хуудсанд байршуулсан байх;
 - 13.10.2 бакалаврын судалгааны ажил 3-аас доошгүй удирдсан байх;
- 13.11. Дэд профессорын албан тушаалын зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 13.11.1 дэд профессор зэрэглэлд энэхүү журмын Хүснэгт 1-ийн 2-р мөрөн дэх оноог (Хавсралт 1) биелүүлсэн байх;
 - 13.11.2 ахицын онооны 60 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны (Хүснэгт-2 дахь оноогоор тооцогдох) онооны үзүүлэлтээр гүйцэтгэгдсэн байх;
 - 13.11.3 МУИС-ийн бус санхүүжилтийн эх үүсвэрээр судалгааны туслах ажиллуулдаг байх;
- 13.12. Дэд профессорын зэрэглэл баталгаажуулах нөхцөлд дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:
 - 13.12.1 МУИС-ийн магистрантын эрдэм шинжилгээний ажил 5-аас цөөнгүйг удирдаж хамгаалуулсан байх;
 - 13.12.2 ахицын онооны 60 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны (Хүснэгт-2 дахь оноогоор тооцогдох) онооны үзүүлэлтээр гүйцэтгэгдсэн байх;
- 13.13. Профессорын зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллахад дараах шаардлагыг хангасан байна:
 - 13.13.1 дэд профессорын зэрэглэлд баталгаажсан байх;
 - 13.13.2 профессорын зэрэглэлд энэхүү журмын Хүснэгт 1-ийн 2-р мөрөн дэх оноог (Хавсралт 1) биелүүлсэн байх;
 - 13.13.3 ахицын онооны 70 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны (Хүснэгт-2 дахь оноогоор тооцогдох) онооны үзүүлэлтээр гүйцэтгэгдсэн байх;
 - 13.13.4 МУИС-ийн бус санхүүжилтийн эх үүсвэрээр 2-оос доошгүй судалгаа, сургалтын туслахыг ажиллуулсан байх;
 - 13.13.5 тэнхимээр батлагдсан судалгааны семинар жилд 12-оос доошгүй удаа тогтмол удирдан явуулсан байх;
 - 13.13.6 бакалаврын түвшний ерөнхий суурийн эсвэл мэргэжлийн суурийн хичээл заадаг байх.
- 13.14 Профессорын зэрэглэл баталгаажуулахад дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:
 - 13.14.1 суралцах хугацааных нь туршид удирдаж МУИС-ийн 2-оос цөөнгүй докторантыг хамгаалуулсан байх;
 - 13.14.2 ахицын онооны 70 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний үйл ажиллагааны (Хүснэгт-2 дахь оноогоор тооцогдох) онооны үзүүлэлтээр гүйцэтгэгдсэн байх;
 - 13.14.3 Хүснэгт 1.1-ийн 3-р мөрөнд дурдсан оноог биелүүлсэн байх.
- 13.15 Багш нар зэрэглэлийн шаардлага хангасан эсэхийг холбогдох нотлох баримт, тайлбарын хамт ЭШММС-т оруулж бүрдүүлнэ.
- 13.16 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар томилогдсон, ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн нэгжид харьяалалгүй төлөөлөл бүхий үнэлгээний хороогоор үнэлүүлнэ.
- 13.17 Үнэлгээний хорооны ажлын үр дүнг бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрээ МУИС-ийн үнэлгээний хороонд 06-р сарын 01-ны дотор ирүүлнэ.
- 13.18 Урт хугацааны томилолтоор ажиллаж буй багш нь үнэлгээний хугацаанд зэрэглэлд тавигдах шаардлага хэрхэн хангасан тухай холбогдох баримт, тайлбарыг үнэлгээний хороонд ирүүлж

- нэгдсэн үнэлгээнд хамрагдана. Холбогдох хугацаанд үнэлгээнд ороогүй багш нь томилолтоос эргэн ирэх үед тухайн нэгжид байгаа сул орон тоонд ажиллах бөгөөд уг орон тооны зэрэглэлийн шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- 13.19 МУИС-ийн захирлын тушаалаар томилогдсон үнэлгээний хороо шийдвэрээ 06-р сарын 15-ны дотор МУИС-ийн захиргаанд ирүүлнэ. Багшийн ажиллах албан тушаалын зэрэглэлийг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 13.20 Багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд үндэслэн багш тухайн албан тушаалын зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллах, зэрэглэл ахих шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулна.
- 13.21 Нэгдсэн үнэлгээний холбогдох шаардлагыг хангаагүй багшид захиргааны зүгээс Хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг өөрчилж ажиллах санал тавина.
- 13.22 Профессорын зэрэглэлийн нэг орон тоонд уг болзлыг хангасан хэд хэдэн багш байх тохиолдолд Хавсралт 1 /Хүснэгт-2/-д заасны дагуу оноогоор шалгаруулна.
- 13.23 Science, Nature, Cell г.м. Web of Science, Scopus импакт фактор нь 20-оос дээш мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор 1 өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний үзүүлэлт бүрэн биелсэнд тооцож болно. Эдгээр оноог тооцохдоо сүүлийн 5 жилийн Web of Science, IF-JCR, Scopus, импакт фактор индекс бүхий байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухааны сэтгүүлийн эшлэлийн тайланг үндэслэн тогтооно.
- 13.24 Инженер, математик, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын судалгааны оноонд Web of Science импакт фактор индекс бүхий мэдээллийн санд бүртгэгдсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэл, өгүүлэл, МУИС-ийн нэрээр бүртгүүлсэн патент, захиалгат судалгаа, технологи дамжуулалтын нийлбэр оноог судалгааны онооны 30 хувь хүртэл хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Web of Science, IF-JCR, Scopus, импакт фактор индекс бүхий мэргэжлийн сэтгүүлд мэдээллийн санд бүртгэгдсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэл, өгүүлэлд өгөх оноог IF-JCR индексгүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлтэй дүйцүүлэн тооцно.
- 13.25 Профессорын, дэд профессорын зэрэглэлд хоёр удаа буюу нийт 6 жилийн хугацаагаар тус тус ажиллаж, харгалзах зэрэглэлийн шаардагдах оноог бүрэн биелүүлж, зэрэглэл баталгаажуулах шаардлагыг хангасан нөхцөлд харгалзах зэрэглэл дээр дахин шалгаруулалтгүйгээр ажиллах эрхтэй болно.
- 13.26 Дэд профессор, профессорын зэрэглэлд баталгаажсан багшийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр батламжилна.
- 13.27 Энэхүү журам хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө МУИС-ийн профессор, дэд профессор цол авсан багш нь харгалзах зэрэглэл дээрээ шалгаруулалтгүйгээр ажиллана.
- 13.28 МУИС-ийн захирал, дэд захирал, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, газар, алба, хэлтсийн даргын албан тушаалд ажилласан хугацааг өмнө ажиллаж байсан зэрэглэлд ажилласнаар дүйцүүлж тооцох бөгөөд зэрэглэлдээ буцаж ажиллах үед тухайн зэрэглэлд тавигдах шаардлагын дагуу бусад багшийн адил хангаж, үнэлүүлнэ. Багш нарын хувьд энэ журам хэрэгжиж эхлэхээс өмнөх тухайн албан тушаалын зэрэглэлд ажиллаж байсан хугацаа нь журмын 13.25-д заагдсан хугацаанд орж тооцогдоно.
- 13.29 Профессор, дэд профессорын орон тоонд болзол хангасан багш байхгүй тохиолдолд шаардлагыг бууруулж орон тоог нөхөж ажиллахыг хориглоно.
- 13.30 МУИС-д судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж цалингийнхаа тодорхой хувийг төслөөсөө санхүүжүүлэн ажиллаж байсан багшийг цалингийн эх үүсвэр нь дуусгавар болсон тохиолдолд өмнө ажиллаж байсан зэрэглэл дээр үргэлжлүүлэн ажиллуулна.
- 13.31 Багш дараагийн зэрэглэлийн шалгаруулалт болохоос 2 жилээс хэтрэхгүй хугацааны өмнө өндөр насны тэтгэвэрт гарах хүсэлтээ ЗХНХН-д өгсөн тохиолдолд зэрэглэлийн шалгуураас чөлөөлөгдөнө.

Арван дөрөв. Бусад зүйл.

- 14.1 Энэхүү журам 2022 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 14.2 Энэхүү журмын заалт нь 2022 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хүснэгт 1. МУИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэлийн ахицын оноо

Онооны шатлал	Албан тушаалын зэрэглэл			
	Багш	Ахлах багш	Дэд профессор	Профессор
Зэрэглэл ахих оноо (эхлэн ажиллах)	шаардлага хангах	1400	2200	3400
Ахицын оноо 1 (зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллах)	1000	1800	2800	4060
Ахицын оноо 2 (Зэрэглэл баталгаажуулах)	шаардлага хангах	шаардлага хангах	3400	4720

Хүснэгт 1.1 МУИС-ийн албан тушаалын зэрэглэл ахих, баталгаажуулах онооны хуваарилалт

Албан тушаал	Эрдэм шинжилгээ	Сургалт/ Нийгмийн үйлчилгээ	Нийт
Зэрэглэл ахих			
Багшаас ахлах багш	560	840	1400
Ахлах багшаас дэд профессор	1100	1100	2200
Зэрэглэл баталгаажуулах			
Дэд профессор	2380	1020	3400
Профессор	3780	940	4720

Тайлбар: Хүснэгтэд үзүүлсэн харгалзах оноог бүрэн биелүүлнэ.

Хүснэгт 2. Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг тооцох онооны шатлал

Эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлт	Оноо
Web of Science болон IF-JCR импакт фактор индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл ³	400
Scopus -ийн индекс бүхий сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл ³	400
Web of science-д бүртгэлтэй боловч импакт факторгүй Emerging Sources Citation Index (ESCI), Art & Humanities Citation Index (AHCI) ³	300
Олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг /peer-review/ олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл ³	160
Дотоодод англи хэлээр хэвлэгддэг, мэргэжлийн түвшинд хянагддаг, олон улсын редакцийн зөвлөл бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл ³	100
МУИС-д бүртгэлтэй мэргэжлийн түвшинд хянагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл ³	80

³Хамтын бүтээлд оноог тухайн бүтээлд зохиогчийн оруулсан хувь нэмрээс хамааруулан 1-р зохиогчид бүтнээр, холбоо барих зохиогчид 0.8-аар үржүүлж, бусад зохиогчдод 0.5-аар үржүүлж тооцно. Өгүүллийг хэвлүүлсэн эсвэл хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) тохиолдолд үнэлгээнд тооцож болно. Нэг өгүүлэл нэг удаа үнэлэгдэнэ. Scopus-ийн хувьд CiteScore үнэлгээ бүхий сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийг тооцно.

Монограф буюу нэг сэдэвт бүтээл ⁴ - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн.	1200 900 300
Нэг сэдэвт хамтын бүтээл /нэг бүлэг/: - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн.	400 300 100
Боловсруулж баталгаажуулсан патент: - технологийн патент - хэвлэмэл бүтээлийн патент ⁵ /ашигтай загвар	200 50
МУИС-ийн бус санхүүжилттэй төсөл: - МУИС-ийн дансаар оруулсан төслийн нийт санхүүжилтээс төлсөн төслийн шимтгэл, оюутны сургалтын төлбөр, сургалт, судалгааны туслахад олгосон тэтгэлэг болон ажлын хөлс, лаборатори, хээрийн судалгаанд зарцуулсан зардал, биет болон биет бус хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 10%-аар тооцно. /МУИС-ийн эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн байх/ санхүүжилтийн 1 сая төгрөг тутамд	30

Хүснэгт 3. Сургалтын үйл ажиллагааг тооцох онооны шатлал

Сургалт	Хэмжээ	Оноо
Бакалаврын түвшний хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах ⁶	1 хичээл	20
Магистр, докторын хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах ⁶	1 хичээл	35
БШУЯ, МУИС-ийн болон их, дээд сургуулийн консорциумын шилдэг багшийн шагнал авах	1 шагнал	50
- Сурах бичиг ⁷ - орчуулгын бүтээл (зохиогчоос эрх авсан байх)	1 сурах бичиг	150 75
Удирдаж хамгаалуулсан бакалаврын оюутны тоо	1 оюутан	10
Удирдаж хамгаалуулсан магистрын тоо	1 магистрант	30
Удирдаж хамгаалуулсан докторын тоо	1 докторант	60
Гадаад оюутан болон тусгай хөтөлбөрөөр суралцагчийг удирдах	1 хөтөлбөр 1 гадаад оюутан	15 10
Цахим хичээл боловсруулах (online.num.edu.mn сайтад байршуулсан байх)	1 хичээл (1 Бц)	30
Дотоодын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	20
Гадаадын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	40

⁴ Судалгааны хамтарсан бүтээл нь зохиогчдын оролцоо хэвлэлийн хуудсаар тодорхойлно. Тодорхойлох боломжгүй бол бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно.

⁵ Хэвлэмэл бүтээлийг тусад нь үнэлгээнд оруулсан тохиолдолд патентыг давхардуулан тооцохгүй.

⁶ Хичээлийн тодорхойлолт боловсруулах болон сайжруулах ажилд багаар ажилласан бол нийт оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

⁷ Сурах бичиг, орчуулгын бүтээл нь бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн байх ба олон зохиогчтой тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, хэрэв зохиогчдын оролцоо тодорхойгүй бол оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

Шинэ сургалтын арга зүй туршиж нэвтрүүлсэн	1 арга зүй	20
--	------------	----

Хүснэгт 4. Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээг тооцох онооны шатлал

Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	Хэмжээ	Оноо
МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	20
МУИС-ийн болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах (давхардуулж тооцож болно.)	1 хичээлийн жил	10
Их сургуулийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн аль нэг хорооны гишүүнээр, их семинар удирдаж ажиллах	1 хичээлийн жил	20
Сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэгт орж ажиллах, бусад үүрэгт ажил хийж гүйцэтгэх	1 удаа	20
Улсын хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах, сургалт семинар удирдах, оролцох	1 удаа	10
Эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	1 удаа	10
Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	25
Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	15
Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	1 удаа	10
МУИС-ийн төгсөгчдийн холбооны ажилд оролцох	1 хичээлийн жил	20
Мэргэжлийн холбоодын удирдах зөвлөлд болон гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	15